

Сайн байцгаана уу.

Монгол-Японы төвийн ах эгч нар нь та бүхэндээ“進学する留学生のための面接” буюу “Японд суралцах гэж буй гадаад оюутнуудад зориулсан ярилцлагын шалгалт” гэсэн номыг цувралаар танилцуулахаар боллоо.

Тус номыг 2019 оны 4-р сард Японы оюутныг дэмжих байгууллага болох ЖАССО-гоос эрхлэн гаргасан бөгөөд японы их сургуульд суралцахаар төлөвлөж буй та бүхэндээ тус нэмэр болно гэж итгэж байна.



進学する 留学生のための面接

JASSO 日本語教育センター



JDC

Уг ном нь доорх 5 бүлэгтэй.

1-р бүлэг: “Японд сурах болсон эрхэм зорилго” бичихийн өмнө.

Японы их сургуульд ямар чиглэлээр сурахаа хараахан шийдээгүй байгаа хүн ч гэсэн, тус номон дээрх асуултанд хариулангаа юугаар сурахаа шийдэх боломжтой. Сурах чиглэлээ аль хэдийн шийдсэн хүн ч гэсэн асуултанд хариулаад үзээрэй.

2-р бүлэг: “Японд сурах болсон эрхэм зорилго”-ын талаар сайн бодоцгооё.

“Японд сурах болсон эрхэм зорилго”-ыг хэрхэн яаж бичих талаар зөвлөгөөг энэ бүлгээс уншаарай.

3-р бүлэг: Ярилцлагын шалгалтанд түгээмэл ирдэг асуултууд.

Ярилцлагын шалгалтанд түгээмэл ирдэг асуултанд хамтдаа хариулцгаая. Их сургуулийн элсэх өргөдөл дээр бичсэн зүйл болон “Японд сурах болсон эрхэм зорилго”-тойгоо уялдуулан бодож шалгалтын асуултанд бэлдэцгээе.

4-р бүлэг: Ярилцлагын шалгалтанд хэрхэн бэлдэх вэ. /Зурган тайлбартай/

Ярилцлагын шалгалтанд хэрхэн бэлдэх, мөн үеэр хэрхэн биеэ авч явах талаар зурган тайлбараар тайлбарлав.

5-р бүлэг: Салбар тус бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгс.

Мэргэжлийн салбар тус бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгсийг хамтдаа цээжилцгээе.


Энэхүү номонд японы их сургуульд элсэн орохын өмнөх бэлтгэл ажил, ярилцлагын шалгалтанд ямар асуулт голчлон ирдэг тухай, мөн Японд суралцах болсон эрхэм зорилгыг хэрхэн бичих талаарх зөвлөгөөг зурган тайлбартайгаар үзүүлэхээс гадна мэргэжлийн салбар бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгсийг мэдэж авцгаах болно. Одоохондоо мэргэжлээ хараахан сонгож амжаагүй, мөн их сургуулийн ярилцлагын шалгалтанд юу гэж хариулахаа мэдэхгүй хүмүүс байгаа байх гэж бодож байна. Тэгвэл та санаа зовох хэрэггүй. Энэхүү номыг 1-р бүлгээс эхлэн хамтдаа уншингаа ирээдүйн мэргэжлийнхээ талаар бодоцгооё.

За ингээд эхний бүлэг болох “Японд сурах болсон эрхэм зорилго”-оо бичихийн өмнө юуг хийж бэлдэх тухай үзэцгээнэ.

Юуны өмнө та их сургуульд орохоосоо өмнө аль сургуулийн ямар ангид суралцах вэ гэдгээ шийдсэн байх ёстой. Түүний дараагаар тухайн сургуульд суралцах болсон “Эрхэм зорилго”-оо бичнэ. Энэхүү “Эрхэм зорилго”-ыг их сургуулийн элсэх өргөдөл дээр бичихээс гадна ярилцлагын шалгалтан дээр ч асуудаг. За ингээд дараагийн хуудсанд байгаа асуултанд хамтдаа хариулцгаая.

1

Эхлэл



Японд үргэлжлүүлэн суралцмаар байна.

Тийм

Японд суралцах/амьдрах нь дээр гэж бодсон шалтгаан байгаа.

Тийм

2 руу очно

Үгүй/Сайн мэдэхгүй байна

Үгүй/Сайн мэдэхгүй байна

Нутаг буцмааргүй байна

Тийм

Өөр улс руу явмааргүй байна

Тийм

Япон улс таалагддаг/ дуртай

Тийм

Япон улсын яг юу нь танд таалагддаг вэ? Юуг нь илүү дээр гэж боддог вэ? Яагаад өөрийн эх оронд биш, мөн бусад оронд биш, Японд суралцмаар байгаа вэ? Таны суралцах гэж буй мэргэжлийн салбар бусад улстай харьцуулахад Японд хэр хөгжсөн бэ? Яагаад японд суралцмаар байгаа талаар ахин сайн бодоцгооё. "Японд суралцах болсон шалтгаан" –аа тайлбарлаж чаддаг болцгооё.

Үгүй

Үгүй

Сайн мэдэхгүй байна

Үгүй/Сайн мэдэхгүй байна

Японд үргэлжлүүлэн сурах эсэхээ ахин нэг бодож үзэцгээе !




Япон улсад суралцахад "Японд суралцах болсон шалтгаан" хэрэгтэй. Япон улсын яг юу нь, таны эх орон болон бусад орноос ялгаатай вэ. Тэдгээр ялгааны талаар эргэцүүлэн бодоцгооё.



2

Эхлэл



Японд ямар ажил мэргэжил эрэлттэй байдаг талаар бодоцгооё. Ялангуяа гадаад оюутнууд аль салбарт хамгийн их ажиллах боломжтой талаар хамтдаа судалцгаая. ЖАССО-гийн “Гадаад оюутнуудад зориулсан ажил хайх гарын авлага”-ыг доорх линкээр үзээрэй.
https://www.Jasso.go.jp/ryugaku/study_j/job/index.html

10 жилийн дараах өөрийгөө төсөөлөн бодоорой. Японд байна уу? Эх орондоо байна уу? Ямар ажил хийж байна вэ? Ирээдүйнхээ талаар төсөөлөн бодож, яг одооноос юу хийж эхлэхээ сайтар бодоцгооё.

Эх оронд чинь тулгамдаж байгаа асуудал юу вэ? Эх дэлхийд маань тулгамдсан асуудал юу вэ? Эдгээрийн талаар сайн бодоцгооё.



3

Эхлэл

Аль салбарт суралцах хүсэлтэй вэ?

Нийгмийн ухаан

Байгалийн ухаан

5-р бүлгийн "Салбар тус бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгс"-ийг харцгаая

5-р бүлгийн "Салбар тус бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгс"-ийг харцгаая

4 рүү очно

5-р бүлгийн "Салбар тус бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгс"-ийг харцгаая. Аль мэргэжил нь чамд тохирох бол?



Сайн мэдэхгүй байна

Ямартай ч сурах сонирхолтой чиглэл бий

Тийм

Тэр чиглэлээр их сургуульд суралцах боломжтой

Тийм

Тэр чиглэл маань их сургуулийн ямар факультет-д хамаарагдахыг мэднэ

Тийм

4 рүү очно

Үгүй/Сайн мэдэхгүй байна

Сайн мэдэхгүй байна

Үгүй

Үгүй/Сайн мэдэхгүй байна

5-р бүлгийн "Салбар тус бүр дээр түгээмэл хэрэглэгддэг үгс"-ийг харцгаая. Аль салбарт, ямар мэргэжлээр суралцах талаар сайн эргэцүүлэн бодоцгооё.

Сайн мэдэхгүй байна

5 рүү очно

Техник мэргэжлийн сургуульд сонгосон чиглэлээрээ суралцах боломжтой эсэхийг судлаарай.



Их сургуулийн факультетэд ямар ямар мэргэжлээр суралцах боломжтой эсэхийг судалцгаая.

Сайн мэдэхгүй байна

5 рүү очно



4

Эхлэл

Сонирхсон
их сургууль
бий

Тийм

Тэр их
сургуулийнхаа
вэб сайтыг
үзсэн

Тийм

Сургуулийн
танилцуулгыг
захиалсан

Тийм

Сургуулийн
танилцуулгыг
маш сайн
уншсан

Тийм

2-р
бүлэг
рүү
очно
уу

Үгүй

Их сургуулиа
хайцгаая

Өөрийн мэддэг их сургуулиас
эхэлж хайцгаая. Интернэтээр
「〇〇 чиглэлээр элсэлт авдаг
японы улсын их сургууль」
「〇〇 факультет, Токио хавийн
бүс нутаг, хувийн их сургууль」
гэж бичээд хайж үзэцгээе.

JASSO
[https://www.Jasso.go.jp/ryugaku/
study_j/search/index.html](https://www.Jasso.go.jp/ryugaku/study_j/search/index.html)

5 рүү
очно

Үгүй

Сонирхож буй их
сургуулийнхаа
вэб сайт руу нь
ороод үзээрэй.

Вэб сайт руу нь
ороод яг юу харахаа
сайн мэдэхгүй байна

Факультетууд болон
суралцах мэргэжлийн
танилцуулгыг харах

Судлах хичээлүүдийн
танилцуулгыг харах

Төгсөгч оюутнуудын
дипломын ажлын сэдвийг
харах

Багш, профессоруудынхаа
юуг судалж мэргэшсэн
эсэхийг нь хараарай

Үгүй

Сургуулийн
танилцуулгыг
захиалцгаая.
Сургуулийн вэб
сайт-ны бүртгэл
хэсэгт нь
сургуулийн
танилцуулга
захиалах хэсэг бий.

Үгүй

Сургуулийн
танилцуулгаа
уншаарай

Аль хэсгийг нь
уншихаа сайн
мэдэхгүй байна

Та энд бичсэн зүйлсийн алинд
нь илүү ойр байна вэ?



5

Эхлэл

Хаана ямар
мэргэжлээр
сурахаа
шийдчихлээ

Тийм

2-р
бүлэг
рүү
очно
уу

Үгүй/Сайн мэдэхгүй байна

Ямартай ч “суралцах
мэргэжил”-ээ
/дурын/ шийдэж
шалгалт өгөөд үзье

Тэгээд

Сонгосон
мэргэжилдээ
сайн
шамдацгаая

Тэгвэл

Сонгосон
мэргэжлээ
сайн эзэмшиж
чадна

Тэгээд

Их сургуулиа
төгсөхдөө
「〇〇 мэргэжлийг
эзэмшлээ」 гэж
өөртөө итгэл
дүүрэн хэлж чадаж
байвал болох нь
тэр



Чи бакалаврын ангид 4 жил суралцана. Мөн диплом бичиж, судалгааны ажлаа тайлагнана. Тийм болохоор өөрт **「сонирхолтой」** мэргэжлийг сонгон суралцаарай. Тийм болохоор шалгалт өгөхөөсөө өмнө суралцах мэргэжлийнхээ талаар сайтар бодоорой



Ямар мэргэжлээр японд суралцахаа шийдсэн үү? Тийм бол үргэлжлүүлцгээ

2-р бүлэг



“Японд сурах болсон эрхэм зорилго”-ынхоо талаар сайн бодоцгооё!

“Сургуульд суралцах болсон эрхэм зорилго”-нь таны элсэх гэж буй сургуулиас хамаарч харилцан адилгүй бичигддэг. Зарим их сургууль өөрсдийн элсэлтийн өргөдөл дээр бичүүлдэг байхад, зарим нь 「志望理由書」, 「志願理由書」, 「志願票」 гэх материал дээр элсэлтийн өргөдлөөс тусд нь бичүүлж авдаг.

Мөн тухайн сургуулиас гаргасан дэлгэрэнгүй зааварчилгааны дагуу “Эрхэм зорилго” бичүүлдэг сургууль байхад, хураангуйгаар бичүүлж авдаг сургууль бас байдаг.

Дараах 1-4 асуулт нь японы ихэнх сургуулийн элсэх өргөдөл дээр байдаг нийтлэг асуулт юм.

“Сургуульд суралцах болсон эрхэм зорилго”-ынхоо талаар эргэцүүлэн сайн бодоцгооё.

Элсэлтийн өргөдөл дээр юу гэж бичвэл дээр бол?



Тухайн их сургуульд ямар мэргэжлээр суралцах бодолтой байна вэ?
(Аль сургуулийн, ямар ангид, ямар мэргэжлээр суралцах зэрэг)

① Эхлээд, өөрөө бичээд үзье.

.....
.....
.....
.....
.....
.....
.....

② Юу гэж бичихээ тодорхой мэдэхгүй байгаа бол дараах (a~d) асуултанд хариулаад нэг үзээрэй.

а. Та юу сонирхдог вэ?

(Жишээ) Манга, анимэ, япон хэл....

-
-
-

б. Та ямар хичээлд сонирхолтой вэ?

Сургуулийн танилцуулга болон памфлетаас судлах хичээлийн тайлбарыг хараарай

(Жишээ) Япон соёл, япон хэл, харилцан яриа, авиа зүй

-
-
-



с. Яагаад Япон орон гэж?

(Жишээ) Япон хэл болон соёл нь манай орноос өөр учир сонирхолтой санагддаг.

-
-



d. Япон оронд татагдах болсон шалтгаан?

(Жишээ) Хүүхэд байхад анх үзсэн анимэ намайг маш их гайхшруулсан.


-
 -
- 
- 

③ За ингээд, а ~ d асуултанд та юу гэж хариулсан бэ?

Эдгээр асуултын аль нь таньд 「Аль сургуулийн, ямар ангид, ямар мэргэжлээр суралцмаар байгаа」 -гаа тайлбарлаж бичихэд илүү дөхөм болж байна вэ? Өөрийн хариултаа доорх жишээ өгүүлбэрийн адил өгүүлбэрт оруулан бичээрэй.

(Жишээ өгүүлбэр)

Хүүхэд байхад анх үзсэн япон анимэ намайг маш их гайхшруулсан. Тэр анимэ дээр гарсан Япон орны соёл болон ёс заншил нь манай орныхоос тэс өөр байсан учраас Япон орны талаар илүү ихийг олж мэдмээр санагдсан. Гадаад орны соёл болон ёс заншлыг сайн мэдэхийн тулд, тэр орных нь хэлийг судалж мэдэхгүй бол болохгүй. Тиймээс япон хэлийг сонирхож судлах болсон. Ялангуяа манга болон анимэ дээр гардаг харилцан яриа болон, авиа зүйг сонирхон судалж байна. Танай их сургуулийн “япон хэл-япон соёл” гэсэн ангид суралцаж, япон хэлний авиа зүйн талаар судлах хүсэлтэй байна.



① дээр бичсэн зүйлтэйгээ харьцуулаад нэг үзээрэй.
Их сургуульд ямар мэргэжлээр суралцахаар шийдэх
хүртэлх түүх тань бичигдсэн байна уу.
Хамааралгүй зүйл бичсэн байвал ахин нягтлаарай.

Тухайн их сургуульд элсэхийг хүссэн шалтгаан тань юу вэ?

① Эхлээд, өөрөө бичээд үзье.

.....

.....

.....

② Юу гэж бичихээ тодорхой мэдэхгүй байгаа бол дараах (а~с) асуултанд хариулаад нэг үзээрэй.

а. Танд тухайн их сургуулийн юу нь таалагдаж байна вэ?

(Жишээ) Сургуулийн орчин тайван чимээгүй болохоор хичээлдээ төвлөрч чадна. Мөн гадаад оюутнууд ихтэй...





б. Яагаад тухайн их сургуульд суралцахаар болов? Бусад их сургуультай харьцуулахад юугаараа ялгаатай талаар эргэцүүлэн бодоцгооё.

(Жишээ) Тусгайлсан эрдэм шинжилгээний лабораторитой, ○○ багшилдаг, төгсөгчдийн хоорондох холбоо сайн.

-
-
-



с. Япон оронд суралцахаар болсон шалтгаан?

(Жишээ) Суралцах чиглэл болон түүнд тохирсон эрдэм шинжилгээний лаборатори манай улсад байхгүй. Япон улсад ○○ чиглэл маш сайн хөгжсөн.

-
-
-



③ За ингээд, а~с асуултанд та юу гэж хариулсан бэ?

Эдгээр асуултын аль нь таньд 「Тухайн их сургуульд элсэн орох шалтгаан」 -аа тайлбарлаж бичихэд илүү дөхөм болж байна вэ? Өөрийн хариултаа доорх жишээ өгүүлбэрийн адил өгүүлбэрт оруулан бичээрэй.

(Жишээ өгүүлбэр)

Танай их сургуулийн орчин тойрон нь чимээ багатай бөгөөд, энэ нь хичээлдээ төвлөрөхөд маш таатай орчин болно гэж үзэж байна. Мөн япон хэлний авиа зүйн хичээл хийхэд тохиромжтой орчин үеийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй байдаг. Манай улсад танай их сургуулийнх шиг тоног төхөөрөмжтэй сургууль байдаггүй. Мөн анимейшн киноны авиа зүйн судалгаа хийдэг /○○ багш/ багшилдаг. Түүнээс гадна гадаад оюутнууд ихээр суралцдаг болохоор олон янзын соёл болон үзэл бодолтой хүмүүстэй хамт суралцахдаа таатай байна. Төгсөгч оюутнуудаас, танай сургуулийг төгсөгчид хоорондын холбоо сүлжээ маш сайн гэж сонссон. Тоног төхөөрөмж хүрэлцээтэй, олон улсжсан орчинд, мэргэжлийн сайн багш нараар удирдуулан суралцахаар танай сургуулийг сонголоо.



① дээр бичсэн зүйлтэйгээ харьцуулаад нэг үзээрэй.

Таны суралцахаар сонирхож буй их сургууль бусад их сургуультай харьцуулахад ямар ялгаатай талаар сайн мэдэхгүй хүмүүс байвал, их сургуулийн танилцуулга болон нээлттэй өдөрлөгт очиж үзээрэй. Их сургуулийн тойрон аялал болон танилцуулах хичээлд хамрагдаж санал бодлоо чөлөө хуваалцаарай. Сургуулийн үүсэл гарлаас эхлээд их сургууль тань оюутнуудад яг юуг хандаж хэлж байна гэдгийг сайн судалж ойлгоорой.

Их сургуульд элсэн орсоны дараах таны хүсэл эрмэлзэл, суралцах төлөвлөгөөний талаар.

① Эхлээд, өөрөө бичээд үзье.

.....

.....

.....

② Юу гэж бичихээ тодорхой мэдэхгүй байгаа бол дараах (a~b) асуултанд хариулаад нэг үзээрэй.

а. Хэддүгээр курстээ ямар ямар хичээл үзэх вэ?

Сургуулийн танилцуулах хуудас болон вэбсайтаас судлагдахуун хичээлүүдийн талаар сайтар судлах.

(Жишээ) 【1 болон 2-р курс】 "Япон хэл судлал" болон "Авиа зүйн хичээл"-ийг сонгож, япон хэлний авиа зүйн талаар мэдлэгийг хуримтлуулна...

【3 болон 4-р курс】 ○○багшийн семинарт сууж, авиа зүйн хичээлийг ахисан түвшинд сурч, [Анимейшн киноны авиа зүй] гэдэг сэдвээр диплом бичнэ...

.....



б. Хичээлээс гадуурх клубийн үйл ажиллагаа, сайн дурын ажил зэрэгт хамрагдах уу? Хамрагдах бол яг ямар үйл ажиллагаанд хамрагдах вэ?



(Жишээ) Анимейшн кино сонирхогчдын уулзалт, харилцан бие биедээ өөрийн орны хэл заах, сайн дурын ажил.....

-
-
-



③ За ингээд, а~b асуултанд та юу гэж хариулсан бэ?

Эдгээр асуултын аль нь таньд 「Их сургуульд элсэн орсоны дараах суралцах төлөвлөгөөний талаар, хүсэл эрмэлзэл」 -н талаар тайлбарлаж бичихэд илүү дөхөм болж байна вэ? Өөрийн хариултаа доорх жишээ өгүүлбэрийн адил өгүүлбэрт оруулан бичээрэй.

(Жишээ өгүүлбэр)

Их сургуульд элсэн орсоныхоо дараагаар, эхлээд “Япон хэл судлал” “Авиа зүйн хичээл”-ийг судалж, япон хэлний авиан зүйн талаар мэдлэг хуримтлуулна. Түүний дараагаар 3-р курстээ, ○○ багшийн семинарт хамрагдаж авиа зүйн хичээлийг ахисан түвшинд суралцмаар байна. Тэгээд, 4-р курстээ [Анимейшн киноны авиа зүй] гэсэн сэдвээр диплом бичих бодолтой байна. Хичээлээс гадуурх олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдана. Жишээлбэл анимейшн кино сонирхогчдын уулзалтад оролцож, өөртэйгөө адилхан сонирхолтой япон найзуудтай болохыг хүсч байна. Мөн харилцан бие биедээ өөрийн орны хэлийг заах болон өөр бусад сайн дурын ажил хийх зэргээр тухайн бүс нутгийн хүмүүстэй харилцаа холбоо тогтоох бодолтой байна.



① дээр бичсэн зүйлтэйгээ харьцуулаад нэг үзээрэй.
Их сургуульд яг ямар ямар мэргэжлээр суралцаж болох талаар, мөн ямар клубийн үйл ажиллагаа байдаг талаар дээд ангийн ах эгч нараасаа асуугаарай.

Их сургууль төгссөний дараах төлөвлөгөө болон ирээдүйн карьерийнхаа талаар ярьж өгнө үү.

① Эхлээд, өөрөө бичээд үзье.

.....

.....

.....

② Юу гэж бичихээ тодорхой мэдэхгүй байгаа бол дараах (a~b) асуултанд хариулаад нэг үзээрэй.

а. 5 жилийн дараах өөрийгөө хаана юу хийж байгаагаар төсөөлж байна вэ?

(Жишээ) Магистр суралцаж байгаагаар..., нутаг буцсан байгаагаар..., Япон улсад ажил орсон байна гэж төсөөлж байна....



в. Их сургуульд сурсан зүйлээ төгссөнийхөө дараа хэрхэн үр дүнтэй ашиглах талаар бодож үзэцгээе.



(Жишээ) Анимений компанид авиа зүйн ажилтан болох

-
-
-



③ За ингээд, а~в асуултанд та юу гэж хариулсан бэ?

Эдгээр асуултын аль нь таньд 「 Их сургууль төгссөний дараах төлөвлөгөө, ирээдүйн карьерийнхаа талаар 」 тайлбарлаж бичихэд илүү дөхөм болж байна вэ? Өөрийн хариултаа доорх жишээ өгүүлбэрийн адил өгүүлбэрт оруулан бичээрэй.

(Жишээ өгүүлбэр)

Их сургуулиа төгссөнийхөө дараа “Анимейшн киноны авиа зүй”-н талаар магистрт үргэлжлүүлэн суралцах бодолтой байна. Магистраа төгссөнийхөө дараагаар эх орондоо буцан, Японд сурч мэдсэн зүйл болон өөрийн хуримтлуулсан туршлагаа хуваалцахаар “Анимейшн кино хийдэг компани”-д ажилд орно гэж төлөвлөж байна.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....



① дээр бичсэн зүйлтэйгээ харьцуулаад нэг үзээрэй. Их сургуульд суралцах чиглэл болон ирээдүйн ажил мэргэжил тань хоорондоо холбоотой эсэхийг ахин нэг нягталж үзээрэй.

Доорх 1-4 хүртэлх асуултанд хариулахдаа тухайн их сургуулиас заасан үсгийн тоонд багтааж бичихээ мартуузай.



Хэлэх гэж буй зүйл тань ямар дэс дараалалтай байвал бусдад илүү хүрэх вэ? Энэ талаар нэг бодож үзэцгээе.

① Та доорх 4 асуултанд хэдийнээ хариулсан байх. Тэгвэл одоо өөрийн тань яриа ямар дэс дараалалтай байвал бусдад хүрэхэд илүү хялбар, ойлгомжтой байх бол? ()-ны дотор 1-ээс 4 хүртэл тоог бичнэ үү.

() Тухайн их сургуульд ямар мэргэжлээр суралцах бодолтой байна вэ?

(Аль сургуулийн, ямар ангид, ямар мэргэжлээр суралцах вэ)

() Тухайн их сургуульд элсэхийг хүссэн шалтгаан тань юу вэ?


() Их сургуульд элсэн орсоны дараах таны хүсэл эрмэлзэл, суралцах төлөвлөгөөний талаар.

() Их сургууль төгссөний дараах төлөвлөгөө болон ирээдүйн карьерийнхаа талаар ярьж өгнө үү.



Хэлэх гэж буй зүйл тань заавал 1→2→3→4 гэсэн дараалалтай байх албагүй.

② Аливаа бөглөх зүйлийг тухайн их сургуулиас заасан үсгийн тоонд багтааж бичихийг анхаарна уу. Үсгийн тооны талаар мэдээлэл байхгүй бол эхлээд бичгийн цаасан дээр 1000 үсгэнд багтааж бичээд үзээрэй. Бичиж дуусаад багшдаа шалгуулахаа мартуузай.



“Сургуульд суралцах болсон эрхэм зорилго”-ын хуудсыг заавал **үзгээр** бөглөөрөй. Харандаа болон амархан арилдаг бал битгий ашиглаарай. Мөн уншихад ойлгомжтойгоор маш гаргацтайгаар бичихээс гадна догол мөр ашиглахаа мартуузай.

3-р бүлэг



“Ярилцлагын шалгалтанд түгээмэл ирдэг асуултууд”

“Сургуульд суралцах болсон эрхэм зорилго”-иос гадна доорх асуултууд ярилцлагын шалгалтанд түгээмэл ирдэг.

<Их сургуулийн талаар/ Их сургуульд элсэн орсоны дараах сурах төлөвлөгөө>

<Суралцах чадварын талаар>

<Япон дахь амьдралын талаар>

<Өөрийнхөө тухай/ Өөрийн эх орны талаар>

Энэ бүлэгт ярилцлагын шалгалтанд түгээмэл ирдэг асуултуудыг түлхүү оруулсан байгаа. Эдгээр асуултанд хариулахад тань дэм болох үүднээс багшийн өгөх зөвлөгөөг мөн тусгасан болно. Байдаг л нэг энгийн ерөнхий хариулт өгөхөөс зайлсхийж, өөрийгөө зөв илэрхийлсэн тодорхой хариулт өгцгөө.



<Их сургуулийн талаар/ Их сургуульд элсэн орсоны дараах сурах төлөвлөгөө>

1

Их сургуульд яг юу хиймээр байна вэ? /Суралцах?/

Суралцах мэргэжлийнхээ талаар болон ямар хичээл үзэх сонирхолтой байгаагаа тайлбарлаарай. Мөн яагаад энэ мэргэжлийг сонгох болсон шалтгаанаа мөн дурдаарай.

Хичээлээс гадуур өөр юу хиймээр байгаагаа яриарай. Сайн дурын үйл ажиллагаанд хамрагдах бол түүнийхээ талаар, мөн өөр бусад дугуйлан клуб зэрэгт хамрагдах бол түүнийхээ талаар дэлгэрүүлж ярьж болно.

Би их сургуульд ○ ○ ○ талаар суралцмаар байна. Яагаад гэвэл
Мөн гэж бодож байна.

Миний хувьд ○ ○ ○ сонирхолтой болохоор

.....



2

Их сургуулиа төгсөөд юу хийх вэ?

Их сургуулиа төгссөний дараах төлөвлөгөө тань юу вэ?

Өөрийнхөө хүсэл зорилго болон ирээдүйн төлөвлөгөөнийхөө талаар тодорхой яриарай.

Ажилд орох болох ямар мэргэжлээр хаана /Япон уу, өөрийн эх орон уу/ ажиллах уу гэдгээ хэлээрэй. Их сургуульд суралцсан чиглэлийн дагуу ажилд орох бодолтой бол маш сайн давуу тал болно. Мөн магистрт дэвшин суралцахаар бол яагаад дэвшин суралцахаар болсон шалтгаанаа мөн магистраа төгссөнийхөө дараах төлөвлөгөөгөө ярихаа мартуузай.



Их сургуулиа төгссөнийхөө дараагаар ○ ○ ○ компанид ажилламаар байна.

.....



Их сургуулиа төгсөөд магистрт үргэлжлүүлэн суралцах бодолтой байна.

.....

Магистраа дүүргэснийхээ дараагаар



3

Манай их сургуулийн талаар хаанаас олж мэдсэн бэ?

• Хаанаас мэдсэн бэ? (Их сургуулийн нээлттэй өдөрлөг дээрээс)

• Мэдээллийг хаанаас харсан бэ? (Вэбсайт, Постер зураг гэх мэт)

• Хэнээс сонссон бэ? (Багшаасаа, дээд ангийн ах эгч нараасаа гэх мэт)



.....
.....
оролцоод танай их сургуулийн талаар анх олж мэдсэн.



.....
.....
○ ○ ○ танай их сургуулийг санал болгосон.



4

Их сургуулийн талаарх сэтгэгдлээ хуваалцаач.
Энэ сургуулийн яг юу нь таныг татаж байна вэ?

Сургуулийн танилцуулах семинар болон нээлттэй өдөрлөгт очсон бол их сургуулийн багш нар болон тэндхийн ажилчидтай юуны талаар ярилцсан бэ? Мөн их сургуулийн орчин ямар байсан бэ? Чамд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ?



Тухайн сургуулийн талаар хэнээс анх сонссон бэ? Сургуулийнхаа багшаас уу, аль эсвэл дээд ангийн ах эгч нараас уу? Анх сонссон сэтгэгдэлээ хуваалцаарай.

/Их сургуулийн танилцуулгыг уншаад төрсөн сэтгэгдэл ч байж болно/



Би их сургуулийн нээлттэй өдөрлөгт оролцсон юм.
Тэр үед, мэдэрсэн.



Хэлний бэлтгэлийн багшаасаа энэ сургуулийн талаар анх сонссон. Танай сургуулийн надад таалагддаг.



5

Төлбөр болон амьдрах зардлыг хэрхэн зохицуулах вэ?

Их сургуулийн чинь төлбөрийг хэн төлөх вэ гэдгийг тодорхой хариулаарай.



Цагийн ажил хийх бол хичээлдээ ямар нэгэн хохирол учруулахгүйгээр хийнэ гэдгээ ойлгуулж хэлээрэй.



Их сургуулийн төлбөрийг ○ ○ ○ төлнө.

.....
.....



Их сургуулийн төлбөрийг ○ ○ ○ төлнө.
Мөн төлөө цагийн ажил хийх бодолтой байгаа. Цагийн ажил хийвэл чадна гэж бодож байна. Цагийн ажил хийхдээ хичээлдээ хохирол учруулахгүйгээр хийхээр төлөвлөсөн.



6

Өөр их сургуульд элсэх өргөдөл гаргасан уу?

Хэдийгээр өөр сургуульд элсэх өргөдөл гаргасан ч, тухайн сургуулийн элсэлтийн шалгалтанд тэнцвэл энэ сургуульдаа суралцах хүсэлтэй гэдгээ хэлээрэй.



Зөвхөн энэ сургуульд л суралцах чин хүсэлтэй гэдгээ илэрхийлэх хэрэгтэй.



Өөр их сургуульд элсэх өргөдөл гаргаагүй...



Өөр их сургуульд элсэх өргөдөл гаргасан...

<Суралцах чадварын талаар>

7

Япон хэл хэрхэн яаж сурсан бэ?

Япон хэл сурахад хэцүү санагдсан зүйл юу вэ?

Японд ирэхээс өмнөх сургууль болон ирсэний дараах сургуульд япон хэлийг хэр хугацаатай сурсан бэ?

Япон хэл сурахад хэцүү санагдсан зүйлээ ярихаасаа илүүтэйгээр тэрхүү хэцүү зүйлийг ямар аргаар даван туулсанаа яриарай.

Би Японд ирэхээсээ өмнө.....

Япон хэлний ○ ○ ○ нь хэцүү санагдсан.
Яагаад гэвэл
Тэгээд ○ ○ ○ арга барил ашигласан.



8

Англи хэлний тань чадвар хэр вэ?

TOEFL зэрэг англи хэлний шалгалт өгч тодорхой хэмжээгээр хэлний түвшинээ үнэлүүлсэн бол авсан оноогоо танилцуулаарай.



Англи хэлний шалгалт өгч байгаагүй бол англи хэлнийхээ мэдлэгийг хэр түвшинд байгаа гэдгээ илэрхийлээрэй.
Жнь: Сонин уншиж чаддаг эсэх, харилцан яриа өрнүүлэх чадварын талаар зэрэг тодорхой ярьж өгөөрэй.



(Хэзээ?).....
(Ямар?).....шалгалт өгсөн.

.....
.....



TOEFL зэрэг англи хэлний шалгалт өгч байгаагүй ч

.....
.....



9

Хамгийн сайн чаддаг хичээл тань юу вэ?
Сайн чаддаггүй хичээл байгаа юу?

Хамгийн сайн чаддаг хичээлдээ анх яаж дуртай болсон талаараа яриарай. Мөн тэрхүү хичээлийн тань аль хэсэг нь илүү их таалагддаг талаар тодорхой ярьж өгөөрэй.

Сайн чаддаггүй хичээл байдаг бол заавал яриад байх албагүй ч, тэрхүү хичээлийг маш их хичээл зүтгэл гаргаж хийж чаддаг болсон талаар ярьвал сайн.



Би ○ ○ ○ хичээлийг маш сайн чаддаг.

.....
.....
.....



Миний сайн чаддаггүй хичээл бол ○ ○ ○

.....
.....
.....



<Япон дахь амьдралын талаар>

10

Япон дахь амьдрал хэр байна?

Японы талаарх сэтгэгдлээ хуваалцаач.

Японы ○ ○ ○-ны талаар бодлоо хуваалцаач.

(Япон хоол, Япон соёл, Японы аялал жуулчлалын газар гэх мэтийн талаар)

Японд ирээд өөрийг чинь маш их гайхшруулсан зүйл байвал ярьж өгөөрэй.
Өөрт тохиолдсон явдалаасаа тодорхой ярьвал сайн.

Мөн өөрийн орон болон Япон орны ялгаатай талуудын талаар ч гэсэн ярьж болно.

Япон дахь амьдрал байна.

.....
.....

Япон орны ○○○-нь манай орноос ялгаатай.

Тухайлбал

.....
.....



11

Японд таньдаг хүн болон япон найз байгаа юу?
Тэр хүнтэй хаана яаж танилцсан бэ?

Японд найз болон таньдаг хүн чинь байдаг бол, хаана хэн байдаг талаараа ярьж өгөөрэй.

Тэр хүнтэй ямар харилцаатай байдаг талаараа, мөн хэрхэн танилцаж байснаа яриарай.



Японы ○○-д ○○ маань амьдардаг.

.....
..... үед танилцсан.



Японы ○○-д ○○ маань амьдардаг.

.....
..... үед танилцсан.

< Өөрийнхөө тухай/ Өөрийн эх орны талаар >

12

Өөрийгөө танилцуулна уу.

Өөрийгөө товчоор илэрхийлнэ үү.

Өөрийгөө танилцуулахдаа төрсөн газар, Японд хэзээ ирсэнээ, мөн Японд суралцах болсон зорилго болон өөрийнхөө сонирхдог зүйлийн талаар ярьж өгөөрэй.

Ялангуяа хамгийн их сонирхдог зүйлийнхээ талаар ярьвал сайн. Яагаад тэр зүйлд татагдах болсон талаар болон сонирхдог зүйлээ хийж байхдаа хуримтлуулсан туршлагынхаа талаар ярьж өгөөрэй. Мөн өөрийн эерэг зан байдлын талаар ярьж болно.

Би ○○○ улсаас ирсэн. Намайг ○○○ гэдэг.
(Хэзээ)..... Японд ирсэн.
(Японд суралцах болсон зорилго).....

Миний сонирхолыг ○○○ маш их татдаг.

.....
.....



13

Бүрэн дунд сургуулийн сурагч байхдаа ямар зүйлд сонирхолтой байсан бэ?
Мөн тэр үед ямар нэг үйл ажиллагаанд хамрагдаж байсан бол тэр тухайгаа ярьна уу?

[Сонирхол]: Дуртай хичээл, дуртай спорт...

[Үйл ажиллагаа]: Харьяалагддаг дугуйлан, секц

[Маш хичээсэн зүйл]: Тэмцээнд оролцсон тухай, ямар нэг арга хэмжээнд хамрагдсан тухайгаа ярьцгаая.

Тэрхүү сонирхолоо хэзээнээс эхлэн хийсэн эсэх, яагаад хийх болсон шалтгаан, сонирхолдоо хэрхэн дуртай болсон талаар, мөн ямар зүйлийг хичээнгүйлэн гүйцэтгэж ирсэн талаараа яриарай.



Би бүрэн дунд сургуулийн сурагч байхдаа ○○○-
д маш дуртай байсан,

.....
.....



Миний
хувьд

.....
.....



14

Та ямар хоббитой вэ?

[Би спортоор хичээллэдэг] гэсэн ганцхан өгүүлбэрээр дуусгалгүй, яагаад тухайн спортоор хичээллэх болсон талаараа, түүнд дурлах болсон шалтгаан, мөн ямар төрлийн спортод дуртай эсэх талаараа нэмж тайлбарлаж өгөөрэй.

Тоглоом тоглодог, манга уншдаг зэрэг ерөнхийдөө тоглоомонд дуртай юм байна гэсэн ойлголт төрүүлэхээр зүйл ярихаас зайлсхийгээрэй.



Миний хобби бол ○○○ юм.

.....
.....



Би ○○○ –д дуртай.

.....
.....



15

Эцэг эх тань ямар ажил эрхэлдэг вэ?

Эцэг эхийнхээ ажил мэргэжлийг япон хэл дээр хэрхэн хэлдэгийг нь мэдэж авцгаая.



Тэдний ажил мэргэжлийн талаар товчхон танилцуулахдаа бэлдээрэй.



Манай аав ажил эрхэлдэг.

.....
.....



Миний ээж..... ажил эрхэлдэг.

.....
.....



16

Хамгийн сүүлд уншсан номынхоо талаар яриач.
Мөн таны сонирхолыг татаж буй сүүлийн үеийн мэдээ мэдээллээс хуваалцаач.

Номынхоо нэр болон зохиолчийг нь үнэн зөвөөр хэлээрэй.
Мөн номон дээрх агуулгыг товч бөгөөд ойлгомжтойгоор тайлбарлан өгч, уншсаны дараах сэтгэгдлээ мөн хуваалцаарай.

Мэдээний хувьд гэвэл хэзээ гарсан, аль улсын мэдээлэл вэ гэдгийг нь тодорхой хэлж өгөөрэй. Мөн тэрхүү мэдээний талаар өөрийн бодлоо хуваалцаарай.



Миний хамгийн сүүлд уншсан ном бол “○○○”
зохиолчийн “○○○” нэртэй ном билээ.
Утга агуулгын хувьд бол
Номноос төрсөн сэтгэгдэл.....



Сүүлийн үеийн мэдээнээс “○○○” мэдээ миний
сонирхлыг хамгийн их татсан.
Яагаад гэвэл



17

Танай улсын алдартай зүйл юу вэ?

Өөрийн улс болон Япон улсын ялгаатай зүйл нь юу вэ?

[Алдартай газар]-ын талаар ярих бол хаана байрладаг эсэх, ямархуу газар байдаг талаар, мөн танай орны хүмүүсийн хувьд ямар газарт тооцогддог талаар дурдаарай.
[Алдартай зүйл]-ийн талаар ярих бол юуны тухай, ямар зүйл болох, танай орны хүмүүст тэр зүйл ямар чухал зүйлд тооцогддог талаар ярьж өгөөрэй.

Өөрийн улс болон Япон улс хоёрын ялгааны талаар ярихдаа ерөнхий ялгаатай зүйлүүдийн талаар бус, өөрийн судлах гэж буй салбар чиглэл, мэргэжилтэй холбоотой ялгаатай талуудыг нь дурдаж өгөөрэй.



Манай орны хамгийн алдартай зүйл бол
○○○ юм.
Тэр нь юу вэ гэвэл.....



Манай улс болон Япон улсын хоорондох ялгаа гэвэл ○○○ юм.
.....
.....



Асуултын жагсаалт

Их сургуулийн талаар	1	Их сургуульд яг юу хиймээр байна вэ?
	2	Их сургуулиа төгсөөд юу хийх вэ? Их сургуулиа төгссөний дараах төлөвлөгөө тань юу вэ?
Их сургуульд элсэн орсоны дараах суралцах төлөвлөгөөний талаар	3	Манай их сургуулийн талаар хаанаас олж мэдсэн бэ?
	4	Их сургуулийн талаарх сэтгэгдлээ хуваалцаач. Энэ их сургуулийн яг юу нь таныг татаж байна вэ?
	5	Төлбөр болон амьдрах зардлыг хэрхэн зохицуулах вэ?
	6	Өөр их сургуульд элсэх өргөдөл гаргасан уу?
Суралцах чадварын талаар	7	Япон хэл хэрхэн яаж сурсан бэ? Япон хэл сурахад хэцүү санагдсан зүйл юу вэ?
	8	Англи хэлний тань чадвар хэр вэ?
	9	Хамгийн сайн чаддаг хичээл тань юу вэ? Сайн чаддаггүй хичээл байгаа юу?

Асуултын жагсаалт

Япон дахь амьдралын талаар	10	Япон дахь амьдрал хэр байна? Японы талаарх сэтгэгдлээ хуваалцаач. Японы ○○○ –ны талаар бодлоо хуваалцаач. /Япон хоол, Япон соёл, Японы аялал жуулчлалын газар гэх мэтийн талаар/
	11	Японд таньдаг хүн болон япон найз байгаа юу? Тэр хүнтэй хаана яаж танилцсан бэ?
Өөрийнхөө тухай Өөрийн эх орны талаар	12	Өөрийгөө танилцуулна уу. Өөрийгөө товчоор илэрхийлнэ үү.
	13	Бүрэн дунд сургуулийн сурагч байхдаа ямар зүйлд сонирхолтой байсан бэ? Мөн тэр үед ямар нэг үйл ажиллагаанд хамрагдаж байсан бол тэр тухайгаа ярьна уу.
	14	Та ямар хоббитой вэ?
	15	Эцэг эх тань ямар ажил эрхэлдэг вэ?
	16	Хамгийн сүүлд уншсан номынхоо талаар яриач. Мөн таны сонирхолыг татаж буй сүүлийн үеийн мэдээ мэдээллээс хуваалцаач.
17	Танай улсын алдартай зүйл юу вэ? Өөрийн улс болон Япон улсын ялгаатай зүйл нь юу вэ?	